

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр, Мягмар гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-7
<hr/>	
<i>1. Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл “Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”</i>	3-6
<i>2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	6-7

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 51 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Баттөмөр, Б.Дэлгэрсайхан, Ж.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, Б.Бат-Эрдэнэ.

**Нэг. “Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан Тусгай хяналтын хорооны гишүүнд нэр дэвшүүлэх тухай Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг, Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт гаргасан хүсэлт болон “Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан хариулж, тайлбар хийв.

Б.Энх-Амгалан: “Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 6
Бүгд: 10
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саалтын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Энх-Амгалан: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Энх-Амгалан: Дээрх санал хураалтыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энх-Амгалан: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 18 минут үргэлжилж, 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58.8 хувийн ирцтэйгээр 11 цаг 09 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим, 10 цаг 51 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энх-Амгалан: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс гадаад томилолттой 2, өвчтэй 2, орон нутгийн томилолттой 1, чөлөөтэй 3 байна. Бямбасүрэнгийн Энх-Амгалан, Ганибалын Амартүвшин, Пүрэв-Очирын Анужин, Хавдисламын Баделхан, Нанзадын Наранбаатар, Салдангийн Одонтүяа, Дамдины Цогтбаатар, Нямаагийн Энхболд нар ирсэн байна. Ингээд өнөөдрийн хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Хэлэлцэх асуудал нэг. Тусгай хяналт хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай,

2. Байнгын хорооны тогтоолын төсөл /цаглавар батлах тухай/ гэсэн ийм 2 асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орёе. Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.1.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөрийг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр томилуулах тухай албан тоотыг Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Тогтохсүрэнгээс, Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтүяаг мөн тус дэд хорооны гишүүнийг томилуулах тухай албан тоотыг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэлээс Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар тус тус ирүүлсэн байна. Улсын Их Хурлын даргаас Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэж шийдвэрлүүлэхээр ирүүлсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26.3-д заасны дагуу өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэж байна. Байнгын хороонд Улсын Их Хурлын даргаас ирүүлсэн албан тоотыг уншиж танилцуулъя.

2023 оны 10 сарын 13. Номер 84. Дэд хорооны гишүүнээр томилуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын дарга Занданшатар танаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6, 8.1.8, 33 дугаар зүйлийн 33.1.5 дахь заалтын дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөрийг Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр томилуулах саналыг хүргүүлж байна. Хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж өгнө үү. Бүлгийн дарга Тогтохсүрэн.

2023 оны 10 сарын 10-ны өдөр.
Дугаар 01/26. Дэд хорооны гишүүнээр
томилуулах тухай.

Монгол Улсын Их Хурлан дарга
Гомбожавын Занданшатар танаа.

Монгол Улсын Их Хурлын тухай
хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6, 8.1.8, 33
дугаар зүйлийн 33.1.5 дахь заалтын дагуу
Улсын Их Хурлын дахь Ардчилсан намын
бүлгээс Улсын Их Хурлын гишүүн
Салдангийн Одонтуяаг Тусгай хяналтын
дэд хорооны гишүүнээр томилуулах
хүсэлтийг хүргүүлж байна. Бүлгийн
дарга О. Цогтгэрэл гэсэн байна.
Ирүүлсэн албан тоотыг танилцуулж
дууслаа.

Тогтоолын төслийг та бүхэнд
тараасан байгаа. Тогтоолын төслийг
унишиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын
тогтоол.

Тусгай хяналтын дэд хорооны
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай
хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт
28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг Монгол
Улсын Их Хурлын чуулганы хуралдааны
дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн
26.3, 26.5 дахь хэсгийг үндэслэн Монгол
Улсын Их Хурлаас тогтоох нь.

Нэг.Монгол Улсын Их Хурлын
гишүүн Баагаагийн Баттөмөр,
Салдангийн Одонтуяа нарыг Улсын Их
Хурлын Тусгай хяналтын дэд хорооны
гишүүнээр баталсугай.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс
эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм
тогтоолын төслийг та бүхэнд
танилцуулж дууслаа. Тогтоолын
төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг
хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү.
Ганбат гишүүнээр тасаллаа. Ганбат
гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Ганбат: Энэ тусгай хяналтын
дэд хороо. Энэ одоо бараг мөрдөстэй
ийм албан хаагчдын ажилладаг дэд
хороо, тэр дээр хяналт тавьдаг дэд
хороо гэж ойлгож байна. Олон хүнийг
давхардуулж, ажил үүргийг нь
давхардуулах шаардлагагүй юм. Тэгээд
би өөрийгөө нэр дэвшүүлж байна. Тусгай
хяналтын дэд хороонд. Яагаад гэвэл би
Улсын Их Хуралд 3 жилийн цэргийн алба
хаасан хугацаат цэргийн алба хаасан хүн.
Цэргийн тангараг өргөсөн ахмад цолтой
хүний хувьд би энэ хороонд ажиллах
ёстой гэж өөрийгөө бодож байна. Тийм
бэлтгэгдсэн ийм хүн байгаа. Нөгөө
талаар бол манай бүлгээс дэвшүүлсэн
Одонтуяа дарга маань ажил ихтэй. Дэд
дарга байгаа. Тэгээд цагаатгалын
комиссын дарга байгаа. Тэгээд ажил
үүргийг нь давхардуулах шаардлагагүй
гэж бодож байна. Нэг хүн дээр баахан л
олон ажил үүрэг өгдөг. Нөгөө ажил
үүргээ амждаг ч үгүй, тэгээд нэр төдий
болоод явчихдаг ийм байж таарахгүй
гэсэн ийм зүйлтэй байна. Тэгээд манай
Байнгын хорооны дарга чинь юу билээ
бас бэлтгэгдсэн хүн байх. Аюулгүй
байдлын талаар бас тангараг өргөсөн
цэргийн албан хаагч гэж ойлгож байна.
Та юу гэж бодож байн энэ талаар.

Б.Энх-Амгалан: Ганбат
гишүүний асуусан асуултад хариулъя.
Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн
33 дугаар зүйлийн 33.1-д Их хурал дахь
намын бүлгүүдийн эрх, үүргийг нарийн
тодорхойлж заасан. 33.1.5-д бол
Байнгын, дэд, түр хорооны
бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын
даргатай намын бүлэг зөвшилцөнө гэж
ийм хуультай. Энэ хуулийн дагуу Улсын
Их Хурлын дарга Занданшатарт Улсын
Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооны
гишүүнийг томилуулах тухай албан
тоотыг Улсын Их Хурал дахь Монгол
Ардын намын бүлэг мөн Улсын Их Хурал
дахь Ардчилсан намын бүлгээс тус тус
албан бичгээр ирүүлж, зөвшилцөөд
тэгээд Байнгын хороонд оруулж ирж
байгаа юм. Энэ Тусгай хяналтын дэд
хороо бол манай эрхлэх асуултын хүрээнд

байдаг учраас Байнгын болон дэд хороонд манай Байнгын хорооны гишүүд орох бүрэн эрхтэй. Гэхдээ намын бүлгээрээ хэлэлцээд, намын бүлгээс Улсын Их Хурлын даргад зөвшилцөхөөр санал явуулж, Улсын Их Хурлын дарга Байнгын хороогоор хэлэлцүүлээд Их Хуралд өргөн мэдүүлэх ийм дэгтэй юм байна лээ. Тийм учраас өмнө бас Адьшаа гишүүн бас энэ асуудлыг тавьсан. Тэгээд би Адьшаа гишүүнд хэлсэн. Та бол манай Байнгын хорооны гишүүнээс гарсан байна. Өөрийн хүсэлтээр. Тийм учраас Байнгын хорооны гишүүн Байнгын, дэд болон түр хорооны бүрэлдэхүүнд орох, түүнээс гарах ийм Их Хурлын хуультай. Дэд хорооны бүрэлдэхүүнд зөвхөн харьяалах Байнгын хорооны гишүүд орно гэдэг ийм хариуг өгөөд явуулсан. Энэ удаад бас ингээд 2 бичиг нь хоёулаа ингээд намын бүлгүүдээсээ ирээд хэлэлцэж байгаа учраас энэ бол намын бүлэг дээрээ ярих асуудал байна. Энийг та бүхэн намын бүлэг дээрээ яриад, эцсийн байдлаар нь шийдсэн гэж ингэж ойлгож байгаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлж дууслаа. Баттөмөр гишүүн гадаад томилолттой. Өөрөө бол өргөдлөө намын бүлэгтээ гаргаад, тэгээд бүлэг дээр яриад, даргын зөвлөл дээр яриад, тэгээд асуудал ярьсан юм. Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Бид нар дээр маш их шүүмжлэл байгаа. Ингээд нэр төдий ярьдаг, манан болдог энэ тэр гэсэн ийм шүүмжлэл байна. Тэгээд цэргүүд үхэж байна, амиа хорлож байна, тэгээд хэн ч хариуцлага хүлээдэггүй. Мөн одоо үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлсэн иргэдийг барьж хорьж байна. Ийм юмыг хажуугаар нь ингээд дугуй өнгөрдөг ийм хүмүүс нэгдчихээд ингэж байж таарахгүй ээ. Тухайлбал би Баттөмөр гишүүнээс өөрөөс нь асуумаар байна. Тэгээд энэ дээр байхгүй байна. Энэ асуудлыг хойшлуулъя. Хойшлуулах саналтай байна. Хүн нь байхгүй байхад

энэ асуудлыг яриад, энэ бол одоо намын бүлгийн асуудал биш.

Энэ Тусгай хяналтын дэд хороо гэдэг бол Монгол Улсын аюулгүй байдалтай холбоотой мөн тусгай чиг үүргийн байгууллагуудыг хянадаг төсөв, зардал дээр нь.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Ганбат гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье. Тусгай хяналтын дэд хорооны эрхлэх асуудлын хүрээ бол Дэд хорооны тухай Их Хурлын тухай хуулийн 28.2.5-д заасны дагуу Тусгай хяналтын дэд хороо бол төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, тагнуул болон гүйцэтгэх ажлын талаарх хууль тогтоомжийн биелэлт, улсын хилийн хамгаалалт, төрийн тусгай төрийн тусгай хамгаалалтын асуудлыг авч хэлэлцэх ийм хуультай. Тэгээд одоо бол 2 намын төлөөлөл аль аль нь байдаг. Тийм учраас Ардчилсан намаас өмнө нь энэ Тусгай хяналтын дэд хороонд Өмнөговь аймгаас сонгогдсон Бат-Эрдэнэ гишүүн байсан. Ардын намаас бол Их хурлын дэд дарга байсан Аюурсайхан байсан. Тийм учраас энэ чинь нөхөн орж байгаа ийм юм байгаа юм. Тэгээд энэ дээр бол яалт ч үгүй Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн дагуу бүлгийн эрх, үүргийн асуудал бөгөөд энийг Их Хурлын даргатай зөвшилцөнө гэсэн ийм хуультай юм байна лээ. Тэгээд үүнийхээ дагуу зөвшилцөөд, гишүүд нь өөрсдөө хүсэлтээ гаргаад энэ дэд хороонд оръё гэдэг хүсэлтээ гаргаад тэгээд үүний дагуу орж ирж байгаа учраас энэ бол намын бүлгүүд зөвшилцсөн, Их Хурлын даргаас ч зөвшилцчихсэн тэгээд Байнгын хороогоор хэлэлцэхээр орж ирж байгаа асуудал учраас энийг хойшлуулах ийм дэггүй юм байна гэдгийг хэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Одоо санал хураая. Гишүүд саналаа хурахад бэлдээрэй.

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ. Би бас сая саналаа өгсөн төхөөрөмж ажиллахгүй байна. Төхөөрөмж шалгаадахъя. Амартүвшин гишүүн саналаа өгсөн. Нямаагийн Энхболд гишүүн гишүүн та горимын санал гаргах гэж байна уу. Нямаагийн Энхболд гишүүний микрофоныг өгье. Энхболд гишүүний микрофоныг өгье.

Н.Энхболд: Сая нөгөө карт буруу сольж хийгээд санал хураалт дээр Амартүвшин гишүүн бид 2-ын санал буруу гарчихлаа. Өгснөөс эсрэгээр, тэгээд горимын санал гаргаж байна. Дахиад сая энэ саналыг хүчингүй болгоод дахин санал хураалгаж өгөөч ээ гэж.

Б.Энх-Амгалан: Миний төхөөрөмж ч гэсэн бас ажиллахгүй байна шүү. Нөгөө төхөөрөмжийн хүмүүст хэлээрэй. Энхболд гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 10 гишүүн оролцож, 7 гишүүн зөвшөөрч, 70 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дахиад санал хураалт явуулъя. Санал хураалтын томъёоллыг танилцуулсан. Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 10 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 70 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Уг асуудлыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин танилцуулъя.

11.06 цаг.

Дараагийн асуудалдаа орё.
“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулсан байгаа.

Гишүүдэд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү. Санал хураалт яваагүй байна шүү дээ. Санал хураалтыг цуцалъя. Асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу гэсэн. Алга байсан. Дахиад тийм санал хураалт биш шүү дээ. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү. Алга байна. Одонтуяа гишүүнээр тасалъя. Одонтуяа гишүүн үгээ хэлье.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ саяын юу энэ бүрэлдэхүүний талаар уу. Тэгвэл биш.

Б.Энх-Амгалан: Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос тогтоох нь.

Нэг.Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 148 дугаар захирамжид заасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын

хүрээнд хамаарах хууль, Монгол Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаврыг хавсралтаар баталсугай.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Хоёр.Хэлэлцэх хугацааг хуульд тусгайлан заасан болон бусад Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

Э.СУВД-ЭРДЭНЭ

Гурав.Энэ тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо /Б.Энх-Амгалан/-д, хэлэлцэх асуудлын бэлтгэл хангаж, мэргэжил арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-д үүрэг болгосугай гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан санал хураалт явуулъя. “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 10 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжсн, 80 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Байнгын хорооны хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. Хуралдаан тэтгэвэртээ оролцсон Улсын Их Хурлын гишүүдэд баярлалаа. Байнгын хорооны хуралдаан өндөрлөлөө.

11.09 цаг.